- 2 Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа энэхүү Хэлэлцээрийн Хавсралтын зохих Хэсэгт тодорхойлсон маршрутаар олон улсын агаарын тээврийн үйлчилгээ явуулах боломж бүрдүүгэх зорилгоор энэхүү Хэлэлцээрт заасан эрхийг олгоно. Энд дурьдсан агаарын тээврийн үйлчилгээ болон маршрутыг цаашид "тогтоосон маршрут", "тохиролцсон үйлчилгээ" гэж тус тус нэрлэнэ. Хэлэлцэн тохиролцогч Талуудаас томилогдсон агаарын тээврийн компани буюу компаниуд тогтоосон маршрутаар тохиролцсон үйлчилгээ явуулахдаа, энэ зүйлийн 1-д заасан эрхээс гадна, олон улсын зорчигч, ачаа, шууданг тусад нь юмуу хамтад нь тээвэрлэхээр хөлгийн бүхээгт авах буюу буулгахаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дэх энэхүү Хэлэлцээрийн Хавсралтанд заасан цэгүүдэд буулт хийх эрхтэй.
- 3 Энэ зүйлийн 2 дугаар заалт Хэлэлцэн тохирогч нэг Талаас томилогдсон агаарын тээврийн компанид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дэх нэг цэгээс Хэлэлцэн тохирогч энэ Талын нутаг дэвсгэр дэх өөр нэг цэг ашиг олгох зорилгоор буюу хөлсөөр, зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх эрх олгоогүй гэж ойлгоно.
- 4 Зэвсэгт мөргөлдөөн, улс төрийн зөрчилдөөн түүний өрнөл, эсвэл онцгой юмуу өрийн бус шалтгааны улмаас Хэлэлцэн тохирогч аль нэг Талаас томилогдсон агаарын тээврийн компани ердийн маршрутаараа агаарын тээврийн үйлчилгээ явуулж чадахгүйд хүрвэл, Хэлэлцэн тохирогч нөгөө Тал түр хугацаагаар маршрутын зохицуулалт хийж дурьдсан үйлчилгээг гасралтгүй явуулахад дэмжлэг үзүүлэх хүчин чармайлт гаргана.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

**АГААРЫН ТЭЭВРИЙН КОМПАНИЙГ ТОМИЛОХ
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

- 1 Хэлэлцэн тохирогч Талууд тогтоосон шугамзаар тохиролцсон үйлчилгээ явуулахаар агаарын тээврийн нэг эсвэл түүнээс дээш тооны компанийг томилох эрхтэй бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа уг томилолтоо бичгээр мэдэгдэх ба энэ томилолтоо цуцлах эсвэл өөрчлөх эрхтэй.
- 2 Хэлэлцэн тохирогч нөгөө Тал ийм мэдэгдлийг аавалц энэ зүйлийн 3, 4 дэх заалтыг харгалзан агаарын тээврийн томилогдсон компани эсвэл компаниудад үйл ажиллагаа явуулах зохих зөвшөөрлийг саадгүй олгоно.
- 3 (а) Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн Засгийн газар агаарын тээврийн томилогдсон компанид энэ зүйлийн 2 дэхь заалтын дагуу үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзах эсвэл Монгол Улсын Засгийн газар юмүү Монгол Улсын иргэд агаарын тээврийн энэ байгууллагын үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт тавих, түүний өмчийн дийлэнх хэсгийг эзэмших эрх эдэлж буй эсэхэд эргэлзсэн аливаа тохиолдолд агаарын тээврийн томилогдсон байгууллагад энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-т заасан эрх эдлэхэд зайлшгүй гэж үзсэн тийм нөхцөл тавих эрхтэй.
(б) Монгол Улсын Засгийн газар агаарын тээврийн томилогдсон компанид энэ зүйлийн 2 дэхь заалтын дагуу үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзах эсвэл агаарын тээврийн томилогдсон компани хамтарсан үйлдвэрийн хэлбэрээр байгуулагдсан болон үйл ажиллагаа явуулах үндсэн төв нь Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсэд байрладаг эсэхэд эргэлзсэн аливаа тохиолдолд агаарын тээврийн томилогдсон байгууллагад энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-т заасан эрх эдлэхэд зайлшгүй гэж үзсэн тийм нөхцөл тавих эрхтэй.
- 4 Хэлэлцэн тохирогч нэг Талын нисэхийн удирдах байгууллага олон улсын агаарын тээврийн харилцаанд ердийн журмаар болон зүй ёсоор мөрддөг хууль тогтоомжуудад заасан нөхцөл шаардлагыг биелүүлэх чадвартай эсэхийн нотолгоог Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас томилогдсон агаарын тээврийн байгууллагаас шаардаж болно.
- 5 Агаарын тээврийн байгууллага ийнхүү томилогдон эрх авалц энэхүү Хэлэлцээрийн зохих нөхцлүүдийг биелүүрсэн тохиолдолд тохиролцсон үйлчилгээгээ хэзээ ч эхэлж болно.

ТАВДУГААР ЗҮЙЛ

**ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ
ЦУЦЛАХ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ**

- 1 Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас томилогдсон агаарын тээврийн компанид энэхүү Хэлэлцэрийн 3 дугаар зүйлийн 2 дахь зөвлөлдөнд тодорхойлсон эрх эдлүүлэхээр олгосон үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд цуцлах, түдгэлзүүлэх эсвэл эдгээр эрх эдлэхэд шаардлагатай гэж үзсэн болзол тавих эрхтэй. Үүнд
 - (a) (i) Монгол Улсын Засгийн газар юмуу Монгол Улсын иргэд агаарын тээврийн энэ байгууллагын үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт тавих, түүний өмчийн дийлэнх хэсгийг эзэмших эрх эдэлж буй эсэхэд Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн Засгийн газар эргэлзсэн аливаа тохиолдолд;
 - (ii) Тухайн агаарын тээврийн байгууллага хамтарсан үйлдвэрийн байдлаар үүсэн байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа нь Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсэд төвлөрдөг эсэхэд Монгол Улсын Засгийн газар эргэлзсэн аливаа тохиолдолд;
 - (b) Зөвшөөрөл олгосон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг агаарын тээврийн тухайн байгууллага дагаж мөрдөөгүй бол;
 - (c) Тухайн агаарын тээврийн байгууллага энэхүү Хэлэлцэрт дурьдсан нөхцлийг аливаа хэлбэрээр биелүүлээгүй зэрэг болно
- 2 Энэ зүйлийн 1 дэх зөвлөлдөнд дурьдсан эрх цуцлах, түдгэлзүүлэх эсвэл болзол тавих арга хэмжээг хууль тогтоомжийг цаашид аврчих явдлыг таслан зогсоох үүднээс нэн даруй хэрэгжүүлэх шаардлага гарсаггүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талтай зөвлөлдсөний дараа хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

ТОХИРОЛЦСОН ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ ЗАРЧМУУД

- 1 Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниуд тогтоосон маршрутаар, тохиролцсон үйлчилгээ явуулах шударга, тэгш боломжоор хангагдана.
- 2 Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниуд тохиролцсон үйлчилгээ эрхлэхдээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилсон агаарын тээврийн компаниуд тухайн маршрут буюу түүний хэсэгт хийж буй тээвэрт нь хохирол учруулахгүй байхыг эрмэлзэн, ашиг сонирхлыг нь харгалзана.

3. Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниудын эрхэлж буй тохиролцсон үйлчилгээ нь тогтоосон маршрутгаар явагдах нийтийн тээврийн хэрэгцээтэй нягт уялдан байх бөгөөд агаарын тээврийн компанийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр рүү юмуу нутаг дэвсгэрээс зорчигч, ачаа, шуудан тээвэрлэх одоогийн болон зүйн дагуу өсөн нэмэгдэх хэрэгцээтэй нийцэх багтаамжийн ачлаллын хүчин зүйлийг хангах эн тэргүүний зорилготой байна. Агаарын тээврийн компанийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын нутаг дахь тогтоосон маршрутын дагуух цэргүүдээс өөр цэргүүдэд зорчигч, ачаа, шууданг хөлгийн бүсээг авах, бүүлгах нөхцлүүд багтааж дараах хүчин зүйлээс хамаарах өрөнхий зөрчмид нийцсэн байна. Үүнд:
 - (а) агаарын тээврийн компанийг томилсон Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр рүү болон нутаг дэвсгэрээс хийх тээврийн хэрэгцээ;
 - (б) тухайн бус нутаг бүрэлдэхүүнд нь ордог тэр Улсын агаарын тээврийн компани эрхэлж буй агаарын тээврийн бүсэд үйлчилгээг харгалзан тохиролцсон үйлчилгээ дамжин өнгөрч буй бус нутгийн тээврийн хэрэгцээ;
 - (с) дамжин өнгөрөх нислэг үйлдэж буй агаарын тээврийн компанийн хэрэгцээ зэрэг болно.
4. Тогтоосон маршрутгаар үйлдэж буй нислэгийн багтаамжийг Хэлэлцэн тохирогч Талууд үе үе хамтран тодорхойлж байна.

ДОЛООДУГААР ЗҮЙЛ

ТАРИФУУД

1. Тариф гэдэг нэр томъёо нь дөрвөх утгыг агуулна:
 - (а) зорчигч, тэдгээрийн тээшийг тогтмол аяллын нислэгээр тээвэрлэхэд агаарын тээврийн компанид төлөх үнэ, тэдгээр тээвэрлэлттэй уялдан гарах үйлчилгээнд төлөх үнэ;
 - (б) тогтмол аяллын нислэгээр ачаа (шууданг оруулалгүй) тээвэрлэхэд агаарын тээврийн компанид төлөх үнэ;
 - (с) ашигт ажиллагааны шимтгэлийг оролцуулан аливаа үнэ, ханшийн боломж эсвэл түүний хэрэгцээнийг зохицуулах нөхцлүүд;
 - (д) агаарын тээврийн байгууллагаас худалдааны төлөөлөгчдөд тасалбар борлуулсны болон тогтмол аяллын нислэгээр тээвэрлэх ачааны датагдах хуудасны бүрдүүлэлт хийсний төлөө төлөх шимтгэлийн хэмжээ.
2. Хэлэлцэн тохирогч Талуудын томилсон агаарын тээврийн компаниуд Хонг Конгийн Засаг Зөвлөлийн Онцгой Бүс, Монгол Улсын хооронд хийх тээвэрлэлтэндээ хэрэглэх тарифуудыг Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд баталсан байх бөгөөд тохиролцсон

- үйлчилгээний өшиглалтын зардал, ашиглагчдын ашиг сонирхол, зүй зохист ашиг болон тухайн маршрутаар юмуу түүний хэсэгт тээвэр хийж буй агаарын тээврийн бусад компаний тариф зэвэг мөлөөлөх бүх хүчин зүйлийг харгалзан зохистой түвшинд тогтоосон байна
- 3 Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн компаниуд энэ Зүйлийн 2 дугаарт заасан тарифийг батлуулахаар танилцуулахаасаа өмнө тухайн маршрутаар юмуу түүний хэсэгт тээвэр хийж буй агаарын тээврийн бусад компанитай зөвлөлдөж болно. Гэхдээ агаарын тээврийн томилогдсон байгууллага мөрдөх гэж буй тарифаа агаарын тээврийн бусад компанитай тохиролцоогүй юмуу тухайн маршрутаар агаарын тээврийн өөр компани нислэг үйлддэггүй гэсэн шалтгаанаар танилцуулахаас эсвэл Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд батлахаас татгалзахгүй байна. Энэ болон үүний өмнөх зөвлөлдөх дурьдсан "Тухайн маршрут" гэдэг ойлголтанд нислэг үйлдэж буй маршрутыг нэрлэснээс тогтоосон маршрутын тухай дурддаггүй болно
 - 4 Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүс, Монгол Улсын хооронд хийх тээвэрлэлтэнд мөрдөхөөр авдаг буй аливаа тарифийг үг тарифийг батлуулах гэж буй агаарын тээврийн томилогдсон компани эсвэл компаниуд Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагуудад батлуулахаар оруулах бөгөөд нисэхийн удирдах байгууллагууд энэ зүйлийн нэгдүгээр заалтанд дурьдсан онцлогийг тус бүрд нь тодруулсан хэлбэрээр танилцуулахыг шаардаж болно. Тарифийг мөрдөж эхлэхээс 60 өдөр доошгүй хонгийн өмнө (Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд тохиролцвол үүнээс болно хугацаанд) танилцуулсан байна. Танилцуулж буй тарифийг Хэлэлцэн тохирогч тухайн Талын нисэхийн удирдах байгууллага хүлээн авсан өдрийг танилцуулсан өдөр гэж тооцно
 - 5 Мөрдөхөөр авдаг буй аливаа тарифийг энэ зүйлийн дөрөвдүгээр заалтын дагуу танилцуулсан бол Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд хэзээ ч баталж болох бөгөөд тарифийг танилцуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор (Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд тохиролцвол үүнээс болно хугацаанд) Хэлэлцэн тохирогч нэг Талын нисэхийн удирдах байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагад батлахаас татгалзсан тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол үг тарифийг баталсанд тооцно
 - 6 Тариф батлахаас татгалзсан мэдэгдлийг энэ зүйлийн тавдугаар заалтын дагуу өгсөн бол тарифийг Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд хамтран тодорхойлж болно. Энэ зорилгоор Хэлэлцэн тохирогч нэг Талын нисэхийн удирдах байгууллага тарифийг батлахаас татгалзсан тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагад бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллага Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагуудын хооронд зөвлөлдөөн хийх хүсэлтээ тавьж болох ба Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллага хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зөвлөлдөөнийг хийнэ

- 7 Хэлэлцэн тохирогч нэг Талын нисэхийн удирдах байгууллага тарифийг батлахаас татгалзсан мэдэгдлийг энэ зүйлийн таадуугаар заалтын дагуу өгсөн, уг тарифийг энэ зүйлийн зургадугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд хамтран тодорхойлох чадаагүй бол мөргөөныг энэхүү Хэлэлцээрийн арав тав дугаар зүйлийн заалтын дагуу шийдвэрлэнэ.
- 8 Энэ зүйлийн өсдүгээр заалтанд дурьдсан болон энэ зүйлийн заалтын дагуу тогтоосон тариф, шинээр тогтоосон тарифыг мөрдөж эхлэх хүртэл хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.
- 9 Хэлэлцэн тохирогч хоёр Талын нисэхийн удирдах байгууллагуудын хэлэлцээр, тэдгээрийн харилцан тохирч болох хугацаанаас өөрөөр тарифийн хүчинтэй хугацааг энэ зүйлийн наймдугаар заалтын дагуу сунгахгүй Үүнд:
 - (a) тарифийн хүчинтэй хугацааг тогтоосон бол энэ өдрөөс хойш 12-оос дээш сараар;
 - (b) тарифийн хүчинтэй хугацааг тогтоогоогүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Талын томилсон агаарын тээврийн компани шинээр тогтоон мөрдөх тарифаа Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагуудад танилцуулсан өдрөөс хойш 12-оос дээш сараар
- 10
 - (a) Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн томилсон агаарын тээврийн компани Монгол Улс болон гуравдагч орны хооронд кийх тээвэртээ мөрдөх тарифаа Монгол Улсын, шаардлагатай бол гуравдагч орны, нисэхийн удирдах байгууллагуудаар батлуулна. Монгол Улсын томилсон агаарын тээврийн компани Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой бүс, Монгол Улсаас өөр орны хооронд кийх тээвэртээ мөрдөх тарифаа Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн, шаардлагатай бол гуравдагч орны, нисэхийн удирдах байгууллагуудаар батлуулна.
 - (b) Хэлэлцэн тохирогч нэг Талын агаарын тээврийн томилсон компани ийм тээвэртэлтэнд мөрдөх аливаа тарифаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагад батлуулахаар оруулна. Нисэхийн удирдах байгууллагууд энэ зүйлийн нэгдүгээр заалтанд дурьдсан онцлогийг тус бүрд нь тодруулсан хэлбэрээр танилцуулж шаардаж болох бөгөөд тарифийг мөрдөж эхлэхээс 90-оос доошгүй хоногийн өмнө (удирдах байгууллагууд тохиролцоол үүнээс богино хугацаанд) танилцуулсан байна. Танилцуулж буй тарифийг нисэхийн удирдах байгууллагууд хүлээн авсан өдрийг танилцуулсан өдөр гэх тооцно.
 - (c) Хэлэлцэн тохирогч Талын нисэхийн удирдах байгууллага мөрдөхөөр төвлөж, танилцуулахаар оруулсан аливаа тарифийг хэзээн батлаж болох бөгөөд тарифийг танилцуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор уг тарифийг батлуулахаар оруулсан агаарын тээврийн компанид татгалзсан тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол уг тарифийг баталсанд тооцно.

- (d) Хэлэлцэн тохирогч нэг Талын нисэхийн удирдах байгууллага баталсан болон батлагдсанд тооцсон аливаа тарифийн баталгааг дээрх тарифийг мөрдөж буй агаарын тээврийн томилогдсон компанид 90 хугацаатай мэдэгдэл өгч татан авч болно. Агаарын тээврийн тухайн компани энд дурьдсан хугацааны эцэст дээрх тарифийг мөрдөхөө зогсооно.
11. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нисэхийн удирдах байгууллага агаарын тээврийн томилогдсон компаний батлуулахаар оруулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч энэ Талын нисэхийн байгууллага мөн ижил цэргүүдийн хооронд явуулж буй харьцангуй адил үйлчилгээнд мөрдөж байгаа эсвэл илүү хязгаарлагдмал юмуу түүнээс өндрөөр тогтоосон тарифт түшиглэн (ашиглаж буй маршрутыг заавал дурьдэлгүй, үчийн төвшин, тарифийн нөхцөл мөрдөх хугацаа зэргийг) тогтоосон аливаа тарифийг энэ зүйлийн 5 болон 10(с) заалтын нөхцлийг үл харгалзан батлана.

НАЙЦДГААР ЗҮЙЛ

ГААЛИЙН ХУРААМЖ

1. Хэлэлцэн тохирогч Талуудаас томилогдсон агаарын тээврийн байгууллага олон улсын агаарын тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа агаарын хөлөг, энэ хөлгийн бүхээгт байгаа байнгын тоноглол, шатахуун, тослох материал, жижиглэнгээр худалдан авч болохуйц техник хангалтын зүйл, сэлбэг болон хөдөлгүүр, агаарын хөлгийн бүхээгийн нөөц (хүнс, ундааны зүйл, тамхийг хязгаарлалгүй оролцуулан)-ийг агаарын хөлөг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаанд хөлгийн бүхээгт хадгалах нөхцөлтэйгээр, харилцан адил байх зарчмаар агаарын хөлөг нисэн ирэхэд хийсэн үйлчилгээний үнээс бусад гаалийн хураамж, акцизийн татвар, эдгээртэй ижил төстэй бусад төлбөр хураамжаас чөлөөлнө.
2. Хөлгийн бүхээгийн байнгын тоноглол, шатахуун, тослох материал, жижиглэнгээр худалдан авч болохуйц техник хангалтын зүйл, сэлбэг болон хөдөлгүүр, агаарын хөлгийн бүхээгийн нөөц (хүнс, ундааны зүйл, тамхийг хязгаарлалгүй оролцуулан), Хэлэлцэн тохирогч нэг Талын томилогдсон агаарын тээврийн компаний ялгах тэмдэг бүхий нислэгийн хэвлэмэл тийз, өчөөны дагалдах хуудас, аливаа хэвлэмэл материал, агаарын тээврийн энэ компани өөрөө юмуу түүний нэрийн өмнөөс эсвэл агаарын тээврийн томилогдсон энэ компаний агаарын хөлгийн бүхээгт авч Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт аливаа хураамжгүйгээр оруулж ирсэн өрдийн хэвлэлүүдийг, түүнтэн байнгын тоноглол болон дээрх бусад эд зүйлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээгүүр үйлдэх нислэгийн маршрутын хэсэгт ашиглах байнгын тоноглол болон бусад зүйлсийг Хэлэлцэн тохирогч нөгөө Тал харилцан адил байх зарчмаар агаарын хөлөг нисэн ирэхэд хийсэн үйлчилгээний үнээс бусад гаалийн хураамж, акцизийн татвар, эдгээртэй ижил төстэй бусад төлбөр хураамжаас чөлөөлнө.

3. Энэ зүйлийн 1 дүгээр болон 2 дугаар заалтанд дурьдсан эд материалыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын гавлийн байгууллагын хяналт шалгалтан дор хадгалах шаардлага тавьж болно
4. Энэ зүйлийн 1 дүгээрт заасан байнгын тоноглол болон дээрх бусад зүйлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт энэ Талын Гавлийн байгууллагын зөвшөөрөлтэй буулгаж болно. Ийм тохиолдолд эдгээр байнгын тоноглол болон дээрх бусад зүйлс гавлийн байгууллагын журмын дагуу эргүүлэн авч гарах юмуу аливаа өөр хэлбэрээр ашиглах хүртэл харилцан адил байх зөрчмөөр энэ зүйлийн 1 дүгээрт зааснаар татвар хураамжаас чөлөөлөгдөнө. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө Талын гавлийн байгууллагын удирдлага дээрх байнгын тоноглол, дурьдсан эд материалыг дээр тодорхойлсон үнийг хүртэл гавлийн байгууллагын хяналт дор хадгалах шаардлага тавьж болно
5. Хэлэлцэн тохирогч нэг Талын томилсон агаарын тээврийн байгууллага Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт, энэ Талаас ногдуулах татвар, хурвамжуудаас чөлөөлөгдөх эрхийг мөн адил эдэлдэг агаарын тээврийн байгууллага юмуу байгууллагуудаас энэ зүйлийн (1), (2) дугаар заалтанд дурьдсан байнгын тоноглол, эд зүйлийг, эзэлдэн хэрэглэх, дамжуулахаар хэлэлцэн тохирвол энэ зүйлийн заалтын дагуу татвар хураамжаас чөлөөлөгдөх нөхцлийг эдлэх эрхтэй.
6. Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дээгүүр шууд дамжуулан тээвэрлэж буй тээвэр, өчөөг, агаарын хөлөг нисэн ирэхэд хийсэн үйлчилгээний үнээс бусад гавлийн хураамж, акцизийн татвар, эдгээртэй ижил төстэй бусад төлбөр хураамжаас чөлөөлнө

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

1. Иргэний нисэхийн аюулгүй байданд харшлах хууль бус үйлдлээс хамгаалах талаар хүлээсэн үүрэг нь энэхүү Хэлэлцэрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэдгийг Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа дахин нотолж байна. Хэлэлцэн тохирогч Талууд 1963 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Токио хотноо гарын үсэг зурсан "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон бусад тодорхой үйлдлийн тухай Конвенц", 1970 оны 12 дүгээр сарын 18-ны өдөр Гааг хотноо гарын үсэг зурсан "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай Конвенц", 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Монреал хотноо гарын үсэг зурсан "Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай Конвенц" зэрэг иргэний нисэхийн аюулгүй байданд хамгаарах аливаа хууль зүйн хэм хэмжээнд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна

2. Хэлэлцэн тохирогч Талууд иргэний нисэхийн хөлгийг булаан авах, энэхүү агаарын хөлөг, түүний зорчигч, нисгэх баг түүнчлэн нисэх буудал, агаарын навигацгийн хэрэгсэлтийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус үйлдлүүд, иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн бусад аливаа аюулаас сэргийлэх хүсэлт зөвөц бүхий л шаардлагатай түслэлцвэг харилцан үзүүлнэ.
3. Хэлэлцэн тохирогч Талууд өөр хоорондын харилцаандаа Иргэний нисэхийн олон улсын байгууллагаас тогтоосон нисэхийн аюулгүй байдлын талаарх хэрэглэх боломжтой заалтууд, болон 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс нэгдэн ороход нээлттэй болсон Чикагосгийн Конвенцийн Хавсралтуудын заалтуудыг мөрдлөг болгоно. Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн улсдаа бүртгэлтэй агаарын хөлөг ашиглагчид, нутаг дэвсгэрт нь удирдах төв нь байрладаг юмуу суурин үйл ажиллагаатай, агаарын хөлөг ашиглагчид болон өөрсдийн нутаг дэвсгэр дээрх нисэх буудал ашиглагчдаас нисэхийн аюулгүй байдлын дэрх заалтуудыг мөрдөн ажиллахыг шаардана.
4. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр рүү орох, гарах болон түүний хил хязгаарын дотор байх үед энэ зүйлийн 3 дугаарт заасан нисэхийн аюулгүй байдлын талаарх заалтуудыг мөрдөж ажиллахыг агаарын тээврийн компаниудаас шаардаж байхавр Хэлэлцэн тохирогч Талууд тохирно. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт агаарын хөлгийг хамгаалах түүнчлэн зорчигчид, нисгэх баг, тээвэрлэгдэх эд зүйлс, тээш, ачаа, бүхэлгийн нөөцийг өчмөөс өчмөө болон ачих үзэр үзэлг шалгалт хийхтэй холбогдсон зохих арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлнэ. Хэлэлцэн тохирогч Тал бүр тодорхой аюул заналын эсрэг аюулгүй байдлын зохистой тусгай арга хэмжээ авах талаар Хэлэлцэн тохирогч нөгөө Талын аливаа хүсэлтийг нааштай хүлээн авна.
5. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах юмуу агаарын эдгээр хөлөг, түүний зорчигчид болон нисгэх баг, түүнчлэн нисэх буудал, агаарын навигацгийн хэрэгслийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус бусад үйлдэл гарсан буюу гарч болошгүй үед Хэлэлцэн тохирогч Талууд холбоо барьж, ийм үйлдэл буюу аюул заналыг найдвартай, түргэн таслан зогсооход чиглэгдсэн зохих арга хэмжээг авах замаар харилцан бие биедээ түслэлцвэг үзүүлнэ.

АРАВДУГААР ЗҮЙЛ

СТАТИСТИКИЙН МЭДЭЭГЭЭР ХАНГАХ

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нисэхийн удирдах байгууллага, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нисэхийн удирдах байгууллагын хүсэлтийн дагуу өөрийн томилоон агаарын тээврийн компаний хийж буй тохирогчдын үйлчилгээний багтаамжийг судлахад нь зүй зохисийн дагуу шаардагдаж болох үечилсэн болон статистикийн мэдээгээр хангана. Ийм төрлийн мэдээлэл нь агаарын тээврийн томилогдсон байгууллагууд тохирогчдын үйлчилгээний дагуу хийсэн тээвэрлэлтийн хэмжээг тодорхойлоход шаардагдах бүх мэдээлэл болон тээвэрлэлт эхэлсэн, төгссөн црүүдийн тухай мэдээ өгүүлсэн байна.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

ОРЛОГО ШИЛЖҮҮЛЭХ БА ГУЙВУУДАХ

1. Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн томилсон агаарын тээврийн компани шаардлагатай үедээ орон нутгийн зарлагаас давсан орлогыг Монгол Улсаас Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүс рүү хөрвүүлэх буюу гуйвуулах эрхтэй. Монгол Улсын томилсон агаарын тээврийн байгууллага шаардлагатай үедээ орон нутгийн зарлагаас давсан орлогыг Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсээс Монгол Улс руу хөрвүүлэх буюу гуйвуулах эрхтэй.
2. Орлогыг хөрвүүлэх болон гуйвуулга хийхдээ хөрвүүлэг юмуу гуйвуулга хийхээр үйлдсэн мэдүүлгийг үндэслэн тухайн үед мөрдөж буй ханшаар аливаа хязгаарлалтгүйгээр аливаа хөрвүүлэг юмуу гуйвуулга хийж банкны ажиллагааны ердийн хураамжаас өөр хураамж ногдуулахгүй гийнэ.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

**АГААРЫН ТЭЭВРИЙН БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛӨХ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАХ**

1. Хэлэлцэн тохирогч Талуудаас томилогдсон агаарын тээврийн компани Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, суурин суух, ажил эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийн дагуу Хэлэлцэн тохирогч энэ Талын нутаг дэвсгэрт агаарын тээврийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах өөрийн захиргаа, техникийн болон бусад ажилтнуудаа оруулж ирэх, суурин байлгах эрхтэй.
2. Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн томилогдсон компаниуд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өөрөө шууд юмуу худалдааны төлөөлөгчөөр дамжуулан агаарын тээвэр худалдах эрхтэй. Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн томилогдсон компани агаарын тээврийн үйлчилгээ худалдах эрхтэй бөгөөд аливаа хүн үг үйлчилгээг тухайн орны юмуу чөлөөтэй хөрвөдөг алив нэг валютээр чөлөөтэй худалдан авах боломжтой байна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

АШИГЛАГЧИД НОГДУУЛАХ ХУРААМЖ

1. "Ашиглагчид ногдуулах хураамж" гэдэг нэр томъёо нь эрх бүхий байгууллагаас агаарын тээврийн компанид ногдуулдаг буюу нисэх буудал гүүний тоног төхөөрөмж, агаарын навигацийн тоноглол ашигласан, агаарын хөлөг, түүний нисгэх бөг, зорчигчид, ачаанд хамгааралттай үйлчилгээг хийсний төлөө хураамж ногдуулахыг зөвшөөрсөн нөхцлийг хэлнэ.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын томилсон агаарын тээврийн компанид ногдуулах болон ногдуулахыг зөвшөөрсөн хураамж нь олон улсын агаарын тээврийн ижил төрлийн үйлчилгээ явуулдаг агаарын тээврийн өөрийн компанид ногдуулдаг хураамжаас илүүгүй байна.
3. Хэлэлцэн тохирогч Талууд хураамж ногдуулах эрх бүхий байгууллагууд, тонгог төхөөрөмж ашиглан үйлчилгээ авдаг агаарын тээврийн томилогдсон компаниудын хооронд, боломжтой бол агаарын тээврийн компаний төлөөлөгчийн газраар дамжуулан зөвлөлдсөн хийж байхыг дэмжинэ. Ашиглагчдад саналаа илэрхийлэх боломж олгох үүднээс хураамжинд өөрчлөлт оруулах аливаа саналын тухай мэдэгдлийг өөрчлөлт хийхээс өмнө урьдчилан өгнэ. Хэлэлцэн тохирогч Тал бүр агаарын навигаацийн хураамжийн асуудлаар хураамж ногдуулах эрх бүхий байгууллагууд болон агаарын тээврийн компаниуд эзжих мэдээлэл солилцож байхыг цаашд ч дэмжинэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

ЗӨВЛӨЛДӨӨН

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Хэлэлцэрийг хэрэгжүүлэх, түүнийг тайлбарлах, хэрэглэх болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар зөвлөлдөх хүсэлтээ хэдмд ч тавьж болно. Хэлэлцэн тохирогч Талууд өөрсөөр тохиролцоогүй бол Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагуудын хооронд хийгдэх ийм зөвлөлдөөнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Тал хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор эхэлнэ.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

МАРГААНЫГ ЗОХИЦУУЛАХ

1. Энэхүү Хэлэлцэрийг тайлбарлахад буюу хэрэгжүүлэхэд Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд ямар нэг маргаан үүсвэл Хэлэлцэн тохирогч Талууд нэн тэргүүнд хэлэлцээ хийж замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
2. Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд асуудлыг хэлэлцэний замаар шийдвэрлэж эс чадавал харилцан тохирч маргааныг шийдүүлдгээр хувь хүн юмуу байгууллагад хандах юмуу Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр маргааныг шийдвэрлүүлдгээр дараах байдлаар байгуулагдсан гурван арбиторч бүхий арбитрын шүүхэд хандаж болно.
 - (a) маргааныг арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч Тал бүр нийгээд арбиторчийг томилно. Хоёрдагч арбиторчийг томилогдсаны дараах 60 хоногийн дотор урьд томилогдсон 2 арбиторчийн зөвшилцсөнөөр арбиторчийн шүүхийн ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэх, маргааныг хувьд хөндлөнгийн орны иргэнийг гурвадагч арбиторчоор томилно.

- (b) хэрэв дээр дурьдсан хугацаанд аливаа томилолт хийгдээгүй бол Хэлэлцэн тохирогч нэг Тал Иргэний нисэхийн олон улсын байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгчид шаардлагатай томилолтуудыг хийлгэх хүсэлт тавьж болно. Хэрэв Ерөнхийлөгч өөрөө тухайн маргааны хувьд хөндлөнгийн бус орны иргэн байх шалтгаанаар тухайн үүргийг гүйцэтгэж чадахгүй бол үүний ижил шалтгаан байхгүй дараагийн шатны Дэд ерөнхийлөгч томилолтуудыг хийнэ.
3. Хэлэлцэн тохирогч Талууд энэ зүйлд зэвсгээр юмуу үүнээс өөрөөр тохиролцон арбитрайн гурвалсан шүүх өөрийн хууль зүйн ажиллагааны хягаар болон дагийг тогтооно. Гурвалсан шүүхийн удирдамжаар юмуу Хэлэлцэн тохирогч нэг Талын хүсэлтээр арбитрайн шүүхээр хэлэлцэх асуудал, мөрдөх журмыг тодорхойлох хураалдааныг арбитрайн шүүх бүрэн хэмжээгээр байгуулагдсаны дараах 30 хоногийн дотор явуулна.
4. Хэлэлцэн тохирогч Талууд тохиролцсоноор юмуу гурвалсан шүүхийн тайлбарласнаар арбитрайн шүүх бүрэн хэмжээгээр байгуулагдсаны дараах 45 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн тайлбарыг шүүхэд ирүүлнэ. Түүний хариулт дараагийн 60 хоногийн дотор гарсан байна. Хариулт гарсны дараагийн 30 хоногийн дотор Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр юмуу шүүх өөрийн үзэмжээр хэрэг сонсно.
5. Гурвалсан шүүх хэрэг сонссон, аливаа хэрэг сонсгал явагдаагүй бол хоёр Талд хариулт өгсний дараах 30 хоногийн дотор шийдвэрээ бичгээр гаргахыг чөлмөйнэ. Шүүхийн шийдвэрийг олонхийн саналаар гаргана.
6. Хэлэлцэн тохирогч Тал шүүхийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шүүхийн шийдвэрт гэдруулга хийлгэх хүсэлт тавьж болох бөгөөд тийм гэдруулгыг хүсэлт тавьснаас хойш 15 хоногийн дотор гаргана.
7. Хэлэлцэн тохирогч Талууд гурвалсан арбитрайн шүүхийн аливаа шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.
8. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн томилсон арбитрын зардлыг хариуцна. Гурвалсан шүүхийн бусад зардал болон энэ зүйлийн 2(b)-д зэвсэн ажиллагааг явуулахад Иргэний нисэхийн олон улсын байгууллагын Зөвлөлийн Ерөнхийлөгч юмуу Дэд ерөнхийлөгчийн гаргасан зардлыг оролцуулан нийт зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд тэнцүү хэмжээгээр хуваан хариуцна.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Энэхүү Хэлэлцээрт оруулахаар Хэлэлцэн тохирогч Талууд тохиролцсон аливаа өөрчлөлтүүд Хэлэлцэн тохирогч Талууд өөрчлөлт оруулах тухайгаа бичгээр нотолсноор хүчин төгөлдөр болно.

АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ

ЦУЦЛАХ

Хэлэлцэн тохирогч нэг Тал энэхүү Хэлэлцэрийг цуцлахаар шийдсэн мэдэгдлээ бичгээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа хэдийд ч өгч болно. Хэлэлцэн тохирогч Талууд тохиролцоонд хүрч мэдэгдлийг буцааж аваагүй тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Тал Хэлэлцэрийг цуцлах тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш нэг жилийн хугацаа дуусахаас өмнөх өдрийн (мэдэгдэл хүлээн авсан газрын цагаар) шөнө дунд Хэлэлцээр цуцлагдсанд тооцно.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭХ**

Энэхүү Хэлэлцээр түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтүүдийг Иргэний нисэхийн олон улсын байгууллагад бүртгүүлнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

Энэхүү Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно. Энд өгүүтсэн зүйлийг батлан гэрчилж, өөрсдийн Засгийн газруудаас олгосон бүрэн эрхийн дагуу энэхүү Хэлэлцэрт гарын үсэг зурав.

Энэхүү Хэлэлцэрийг 2000 оны 5 дугаар сарын ²⁴ ний өдөр Улаанбаатар хотноо англи, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн болно.

Энэхүү Хэлэлцэрийн бичвэрүүдийн хооронд зөрөө гарсан тохиолдолд англи хэл дээрх бичвэрийг баримтлана.

**БНХАУ-ЫН ХОНГ КОНГИЙН
ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ
БҮСИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС**

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
ӨМНӨӨС**

СТЕФЕН ИП ШУ КВАН

Г. БАТХҮҮ

Хавсралт

МАРШРУТЫН ХУВААРЬ

1 дүгээр хэсэг

Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн томилсон агаарын тээврийн байгууллага юмуу байгууллагууд агаарын тээврийн үйлчилгээ хоёр талдаа явуулах маршрутууд

Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүс - Завсрын цэгүүд -
- Монгол Улс дахь цэгүүд - Хилийн чанад дахь цэгүүд

ТЭМДЭГЛЭЛ:

1. Дээр тогтоосон маршрутын дагуух цэгүүдийг Хэлэлцэн тохирогч Талууд хамтран тодорхойлно.
2. Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсийн томилсон агаарын тээврийн компаниуд эсвэл компаниуд аль нэг эсвэл бүх нислэгтээ дээр тогтоосон маршрутын дагуух цэгүүдийг алгасч болох бөгөөд эдгээр маршрутвар үйлдэх тохиролцсон үйлчилгээ нь Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүсээс эхлэлтэй нөхцөлд завсрын цэгүүд, Монгол Улс дахь цэгүүд болон хилийн чанад дахь цэгүүдтэй аливаа калбараар харилцаж болно.
3. Хэлэлцэн тохирогч Талуудын нисэхийн удирдах байгууллагууд үе үе хамтран тодорхойлсноос өөрөөр Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цэгүүдэд буулгахавар завсрын болон хилийн чанад дахь цэгээс эсвэл үүний сөрөг чиглэлд тээвэрлэхээр хөлгийн бүхэсэг ямар ч вчилт хийдгүй.
4. Хятад Улсын эх газар дахь ямар ч цэгийг завсрын эсвэл хилийн чанад дахь цэг гэж тооцон нислэг үйлдэхгүй.

2 дугаар хэсэг

Монгол Улсаас томилсон агаарын тээврийн байгууллага юмуу байгууллагууд агаарын тээврийн үйлчилгээ хоёр талдөө явуулах маршрутууд

Монгол Улс дахь цэгүүд - Завсрын цэгүүд - Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүс - Хилийн чанад дахь цэгүүд

ТЭМДЭГЛЭЛ

1. Дээр тогтоосон маршрутын дагуух цэгүүдийг Хэлэлцэн тохирогч Талууд хамтран тодорхойлно.
2. Монгол Улсын томилсон агаарын тээврийн байгууллага юмуу байгууллагууд аль нэг эсвэл бүх нислэгтээ дээр тогтоосон маршрутын дагуух цэгүүдийг алгасч болох бөгөөд эдгээр маршрутгаар үйлдэх тохиролцсон үйлчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэртээ эхлэлтэй нөхцөлд завсрын цэгүүд, Хонг Конгийн Засаг Захиргааны Онцгой Бүс дэх цэгүүд болон хилийн чанад дахь цэгүүдтэй аливаа хэлбэрээр харилцаж болно.
3. Хэлэлцэн тохирогч Талуудын агаарын тээврийн удирдах байгууллагууд үе үе хамтран тодорхойлсноос өөрөөр Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цэгүүдэд буулгахаар завсрын болон хилийн чанад дахь цэгээс эсвэл үүний сөрөг чиглэлд тээвэрлэхээр хөлгийн бүхээгт ямар ч ачилт хийггүй.
4. Хятад Улсын эх газар дахь ямар ч цэгийг завсрын эсвэл хилийн чанад дахь цэг гэж тооцон нислэг үйлдэхгүй.

[TRANSLATION -- TRADUCTION]

ACCORD RELATIF AUX SERVICES AÉRIENS ENTRE LE
GOUVERNEMENT DE LA RÉGION ADMINISTRATIVE SPÉCIALE DE
HONG-KONG DE LA RÉPUBLIQUE POPULAIRE DE CHINE ET LE
GOUVERNEMENT DE LA MONGOLIE

Le Gouvernement de la Région administrative spéciale de Hong-Kong de la République populaire de Chine ("la Région administrative spéciale de Hong-Kong") et le Gouvernement de la Mongolie (ci-après dénommés les "Parties contractantes"),

Désireux de conclure un accord afin de mettre en place le cadre nécessaire aux services aériens entre la Région administrative spéciale de Hong-Kong et la Mongolie,

Sont convenus de ce qui suit:

Article premier. Définitions

Aux fins du présent Accord et sauf indication contraire du contexte :

a) L'expression "autorités aéronautiques" s'entend, dans le cas de la Région administrative spéciale de Hong-Kong, du Directeur de l'Aviation civile et, dans le cas de la Mongolie, du Ministère du développement de l'infrastructure, ou, dans les deux cas, de toute personne ou organisme habilité à remplir les fonctions actuellement exercées par lesdites autorités ou des fonctions semblables;

b) L'expression "entreprise désignée" s'entend d'une entreprise de transport aérien désignée et autorisée conformément aux dispositions de l'Article 4 du présent Accord;

c) Le terme "région" concernant la Région administrative spéciale de Hong-Kong s'entend de l'île de Hong-Kong, de Kowloon et des Nouveaux territoires et, concernant la Mongolie, a le sens attribué au terme "territoire" par l'Article 2 de la Convention relative à l'aviation civile internationale, ouverte à la signature à Chicago le 7 décembre 1944;

d) Les expressions "service aérien", "service aérien international", "entreprise de transport aérien" et "escale non commerciale" ont le sens que leur attribue l'Article 96 de ladite Convention;

e) L'expression "le présent Accord" inclut l'Annexe jointe audit Accord et toute modification apportée à ladite Annexe ou au présent Accord.

*Article 2. Dispositions de la Convention de Chicago applicables
aux services aériens internationaux*

Dans la mise en oeuvre du présent Accord, les Parties contractantes se conformeront aux dispositions de la Convention relative à l'aviation civile internationale, ouverte à la signature le 7 décembre 1944 à Chicago, y compris ses Annexes et toute modification à la Convention ou à ses annexes qui s'appliqueraient aux deux Parties contractantes, dans la mesure où ces dispositions sont applicables aux services aériens internationaux.

Article 3. Octroi des droits

1) Chaque Partie contractante accorde à l'autre Partie contractante les droits ci-après concernant ses services aériens internationaux :

- a) Le droit de survoler sa région sans y atterrir;
- b) Le droit de faire escale dans sa région à des fins non commerciales.

2) Chacune des Parties contractantes accorde à l'autre Partie les droits ci-après spécifiés dans le présent Accord aux fins d'exploiter des services aériens internationaux sur les routes indiquées dans la partie correspondante de l'Annexe au présent Accord. Ces services et routes sont ci-après respectivement dénommés "services convenus" et "routes indiquées". Dans l'exploitation d'un service convenu sur une route indiquée, les entreprises désignées de chaque Partie contractante bénéficieront, outre les droits spécifiés au paragraphe 1) du présent article, celui de faire escale dans la région de l'autre Partie contractante aux points déterminés pour la route considérée conformément à l'Annexe au présent Accord, aux fins d'embarquer et de débarquer des passagers et des marchandises, y compris du courrier, soit séparément, soit en combinaison.

3) Aucune disposition du paragraphe 2) du présent article ne sera réputée conférer aux entreprises désignées de l'une des Parties contractantes le droit d'embarquer, en un point de la région de l'autre Partie contractante, des passagers ou des marchandises, y compris du courrier, pour les transporter conformément à un contrat de louage ou contre rémunération à un autre point de la région de l'autre Partie contractante.

4) Si, en raison d'un conflit armé, de troubles ou événements politiques, ou encore de circonstances particulières et exceptionnelles, une entreprise désignée par l'une des Parties contractantes ne se trouve pas en mesure d'exploiter un service sur son itinéraire normal, l'autre Partie contractante fera tout ce qui est en son pouvoir pour faciliter la poursuite de l'exploitation de ce service moyennant des aménagements temporaires adéquats des routes.

Article 4. Désignation et autorisation des entreprises de transport aérien

1) Chacune des Parties contractantes aura le droit de désigner par écrit à l'autre Partie contractante une ou plusieurs entreprises de transport aérien aux fins d'exploiter les services convenus sur les routes indiquées, ainsi que de retirer ou de modifier ces désignations.

